



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/ЗЧЛ

Булган сум

**Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуусын
нийгмийн оролцоог дэмжих чиглэлээр
хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.2, 42.1.4 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуусын нийгмийн тэгш оролцоог хангах, мэдээлэл технологийн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх, харилцаа, холбооны үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор Улаанбаатар хотод зохион байгуулагдах “Мэдээлэл технологийн сорил-2026” улсын уралдаанд оролцогчдын зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2.Зардлын төсвийг хавсралтаар баталж, шаардагдах хөрөнгө болох 725,600 (долоон зуун хорин таван мянга зургаан зуу) төгрөгийн дэмжлэгийг Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

3.Оролцогчдын аюулгүй байдлыг ханган, уралдаанд амжилттай оролцох боломжийг бүрдүүлж ажиллахыг Боловсролын газрын дарга (Ц.Цолмонбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2026 оны
05 дугаар сарын 07-ны/ний өдрийн
А/З/А дугаар захирамжийн хавсралт

**"МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН СОРИЛТ-2026" УЛСЫН УРАЛДААНД
ОРОЛЦОГЧДЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ**

д/д	Сумын нэр	Овог нэр	Регистрийн дугаар	Өвчний онош	Тухайн орон нутгаас Улаанбаатар хот руу очих болон ирэх зардал (төгрөгөөр)	Нийт дүн (төгрөгөөр)
1	2	3	4	5	6	7
1	Баян-Агт	Ж.Мягмарцэцэг	ГА08252507	M08	Том хүн болон хүүхэд 70,000*4=280,000	280,000
2	Рашаант	А.Цагаандарь	ГП08292205	H90.3	Том хүн болон хүүхэд 30,000*4=120,000	120,000
3	Гурванбулаг	Д.Тэмүүлэн	УЦ08230532	G81	Том хүн болон хүүхэд 40,000*4=160,000	160,000
4	Булган	Д.Санчир	ГЮ13290216	H54	Том хүн болон хүүхэд 41,400*4=165,600	165,600
Нийт дүн						725,600

--o00o--